Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ БУЛГАНЫ ЖАРГАЛЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** ТХШТХ-ийн 9.2.1. Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 10.8.1 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулна. | Шинэчлэгдсэн хяналтын хуудас | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76 дугаар тушаал | Батлагдсан хяналтын хуудас | Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024 шинэчлэгдсэнтэй холбоотой ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг шалгах хяналтын хуудас болгон 2 салгаж шинэчилсэн. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг шалгах хяналтын хуудас 10.8.1 кодтой хяналтын хуудсыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулан яамны https://moh.gov.mn/p/163 цахим системд нээлттэй байршуулсан. | 2025.01-2025.03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 2. “ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ 2024 ОНЫ 02 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 2.1.** ТХШТХ-ийн $5^2$.1 Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Увс аймгийн **5** объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | Хяналт шалгалтын танилцуулга | Хяналт шалгалтын танилцуулга | Хяналт шалгалтын танилцуулга гарсан байна | СХГ-ын даргын баталсан 10-00/22 дугаартай удирдамжийн дагуу Увс аймагт төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, төлөвлөсөн объект 100 хувь хяналт шалгалтад хамрагдсан. Эрсдэлийн үнэлгээгээр 1 объект их, 4 объект дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна.Нийт 40 зөрчил дутагдал илрүүлж 23-ыг арилгуулсан. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн хугацаатай 17 заалттай 2 албан шаардлага аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Аймгийн ЗД, Цагаанхайрхан сумын ЗД, Чандмань Увс ОНӨХХК-т хүргүүлсэн. Шалгалтын дүнг ЭМЯ-ны УЗХ-ын 2025.05.02-ны өдрийн хурлаар оруулж хэлэлцүүлсэн. Хяналт шалгалтын явцад усны чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан эсэхийг үнэлэх зорилгоор ундны усны 38 дээж авч улсын байцаагийн 2 дүгнэлт, бохир усны 2 дээж авч улсын байцаагчийн 1 дүгнэлт үйлдэн хүргүүлсэн. Шинжилгээнд хамруулсан ундны ус нь хими, нян судлалын шинжлэгдсэн үзүүлэлтийн хувьд Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, | 2025.04-2025.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. Цэвэрлэх байгууламжийн хаягдал ус нь хаягдал ус техникийн ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын шаардлагыг хангахгүй. | | |
| 3 | **Арга хэмжээ 2.2.** Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, бохир ус цэвэрлэгээний түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | Удирдамж боловсруулан батлуулж, хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, бохир ус цэвэрлэгээний түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10-00/07 дугаартай удирдамж батлуулсан. Аймаг, нийслэлээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэсэн.<br>ХУД-ийн 1 ААНБ-д хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтыг 06-11 сард үргэжлүүлэн хийнэ. | 2025.02-2025.11 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 2.3.** Хот суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. (ЭМЯ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 130) | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | Удирдамж боловсруулан батлуулж, хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10-00/08 дугаартай удирдамж батлуулсан. Аймаг, нийслэлээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэсэн.<br>5 аймгийн төвийн суурьшлын бүсийн хөрсний 26 цэгээс 26 хөрсний дээж авч, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораторид шинжлүүлэн, бохирдлын түвшинд үнэлгээ | 2025.02-2025.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгнэлт өгөв. Шинжлэгдсэн нийт дээжийн 14 буюу 53.85% нь цэвэр, 3 буюу 11.54% нь бага бохирдолтой, 2 буюу 7.69% нь дунд зэргийн бохирдолтой, 7 буюу 26.92% нь их бохирдолтой үнэлэгдсэн. Шинжлэгдсэн дээжийн 3.8%-д Salmonella илэрсэн байна.<br>Хөрсний урьдчилан сэргийлэх хяналт шалгалт үргэлжилж байна. | | |
| 5 | **Арга хэмжээ 2.4.** Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^2$.1-д заасанаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | - | 100% | Шинээр барих болон өргөтгөх барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгэх 4 хүсэлтийг хүлээн авч, нийт 4 зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж, улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт гаргасан. Зураг төсөл, баримт бичгийн бүрдэл дутуу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй 2 хүсэлтэд албан тоотоор хариу өгсөн. | 2025.01-2025.06 | 100 |
| 6 | **Арга хэмжээ 2.5.** Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна. | Сургалтын тайлан | - | Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын 50-иас доошгүй хувийг хамруулан сургалт | СХГ-ын даргын баталсан 10-00/22 дугаартай удирдамжийн хүрээнд Увс аймагт төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан Цагаанхайрхан сумын ЗДТГ, Чандмань Увс ОНӨХХК-ийн ажилчдад 2025 оны 04 дүгээр сарын 11, 14-ний өдрүүдэд дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр сургалт хийсэн. | 2025.04-2025.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулсан байна. | | | |
| **ЗОРИЛТ 3. “ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 7 | **Арга хэмжээ 3.1** Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3 Барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Шийдвэрлэлтийн хувь | - | 100% | Шинээр барих болон өргөтгөх барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгэх 4 хүсэлтийг хүлээн авч, нийт 4 зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж, улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт гаргасан. Зураг төсөл, баримт бичгийн бүрдэл дутуу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй 2 хүсэлтэд албан тоотоор хариу өгсөн. | 2025.01-2025.06. | 100 |
| **ЗОРИЛТ 4. “ОРОН НУТАГ ДАХЬ УЛСЫН /АХЛАХ/ БАЙЦААГЧДЫГ БОДЛОГО, УДИРДЛАГА, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙ, ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 8 | **Арга хэмжээ 4.1.** Орон нутаг дахь улсын байцаагчдыг чадавхижуулах давтан сургалтыг зохион байгуулна. (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024 Шинэчлэгдсэн стандартаар аймаг, нийслэлийн байцаагч нарт | Сургалтын тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо | - | 1 цахим сургалт/ 30 байцаагч | -Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан шилэн хяналтын систем “khyanalt.gov.mn” ашиглах сургалтыг нийт улсын байцаагч нарт 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр цахимаар сургалт хийсэн ба өдөр тутам системтэй холбоотой мэдээллийг цахимаар мэдээлэл өгч ажилласан. - | 2025.03.01-2025.06.01 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт зохион байгуулна) | | | | | | |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах тушаал батлуулах. | Сайдын тушаал | Сайдын 3тушаал | Эрх олгох, цуцлах тушаал батлагдсан байна. | - Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах тухай Эрүүл мэндийн сайдын А/01, А/02, А/03 тушаал боловсруулж батлуулан 2025 оны 01 сарын 08-ны өдрийн 9/120 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 2025.01.02-2025.02.01 | 100 |
| 2 | Шилэн хяналтын системд батлагдсан хяналтын хуудас угсрах, хяналт хийх | Системд угсрагдсан хяналтын хуудас | - | 33 хяналтын хуудсыг системд угсарсан байна. | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан шилэн хяналтын систем “khyanalt.gov.mn”-д батлагдсан 33 хяналтын хуудсыг угсарч хяналт шалгалтын мэдээллийг системд оруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Шилэн хяналтын системд 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын төлөвлөлт үүсгэх, баталгаажуулах, эхлүүлэх хүсэлт хянаж зөвшөөрөх, удирдамж батлах, хяналт хийсэн төлөвт оруулах болон алдаатай үүсгэсэн төлөвлөлт, буруу шалгуураар үнэлсэн эрсдэлийг үнэлгээг засуулах, хянаж баталгаажуулсан.. | 2025.04.01-2025.06.10 | 100 |
| 3 | Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандсан иргэдийн санал, гомдлын мэдээллийн сан үүсгэх | Тайлан | - | Тайлан хүргүүлсэн байна. | 3-6 дугаар сард 454 өргөдөл, гомдол хүлээн авч мэдээллийн сан үүсгэн, шийдвэрлэсэн өргөдөл гомдолыг системд бүртгэсэн. Засгийн газрын 11-11 төв болон бичгээр, мэйлээр, | 2025.04.01-2025.06.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэлтийг системд бүртгэн хаах, 2025 оны 1-р улирлын тайланг хүргүүлэх. | | | | цахимаар ирсэн эрүүл мэндийн салбарын 2025 оны 1-р улирлын өргөдөл гомдлын тайланг нэгтгэн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт албан бичгээр хүргүүлсэн. | | |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Удирдлагын академи ахлах түшмэлийн сургалтад хамрагдана. | Гэрчилгээ | - | Суралцаж эхэлсэн байна | Удирдлагын Академийн ахлах түшмэлийн сургалтанд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хамрагдаж эхэлсэн. 8-н багц хичээлийг суралцаж дууссан. 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр төгсөлтийн шалгалт өгөхөөр товлогдсон байна. | 2025.03-2025.08 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Англи хэлний дунд түвшиний сургалтад хамрагдана. | Гэрчилгээ | Дунд шатны сургалтанд хамрагдаж эхэлсэн. | Дунд шатны сургалтанд үргэлжлүүлэн хамрагдана . | Абсалют англи хэлний сургалтын төвд дунд шатны сургалтад 4 сараас эхлэн хамрагдаж эхэлсэн байна. | 2025.03-2025.12 | 100 |

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН
САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА .......................... О.ЭНХБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ .......................... Б.ЖАРГАЛ 2025.06.10